



ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 07114

Чингис хот

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/212 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын арга хэмжээнд сумын нутаг дэвсгэрт байгаа бүх үхэр, гахайг хамруулан 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт даалгасугай.

2.Дархлаажуулалтад шаардагдах вакциныг татан авч хуваарилах, заавар зөвлөмжөөр хангах, ажлын явц, вакцины зарцуулалт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, вакцин хийх заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн нэгжийн эмч нарт хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Д.Сандагдорж)-д үүрэг болгосугай.

3.Малчдад урьдчилан мэдэгдэж, тарилгын хашаа хоолойг бэлтгүүлэх, бэлэн байдлыг хангаж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Лхагвабаатар)-д даалгасугай

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР